

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд:							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 1.1 заалт. “Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.							
1.1.1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.							
1.	Арга хэмжээ-1: 1.1.2.6. Улаанбаатар хотод тусгаарлан ажиглах байраар ханган, байрны нөөц бүрдүүлж, бэлтгэл бэлэн байдлыг хангана.	-	Тоо	-	-	-“Ковид-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, нийслэл хотод тусгаарлан ажиглах байраар ханган байрны нөөц бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2021 оны А/32 дугаар тушаалаар баталсан хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, тусгаарлан ажиглах байрны нөөц бүрдүүлэх удирдамжийн дагуу холбогдох мэргэжлийн болон хяналтын байгууллагуудын төлөөлөл бүхий 7 дэд ажлын хэсэг 2021 оны 02 дугаар сарын 05-аас 08-ны өдрүүдэд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгаарлан ажиглах байраар ажиллах боломжтой 25-аас дээш өрөөтэй 62 зочид буудалд очиж ажилласан. -Улаанбаатар хотод 3177 ор, 1844 өрөө бүхий 39 тусгаарлан ажиглах байр буюу 37 зочид буудал, 2 амралтын газрын бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, гадаад улс орноос тусгай үүргийн нислэгээр ирсэн, дотоодын халдвар авсан иргэдийг байрлуулан ашиглаж байна.	100%

Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
3.4 заалт. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.

1.	<p>Арга хэмжээ-2: 3.4.1.1. Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ.</p>	<p>ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 25.0 сая.төг</p>	<p>Мэдээлэл авсан хүний тоо</p>	<p>5000</p>	<p>6000</p>	<p>-Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх жуулчны мэдээллийн төвүүдийг ажиллуулж байна. Үүнд: • Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай” А/31 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Засаг захиргааны IV-р байранд Жуулчны мэдээлэл сурталчилгааны төв, • Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аяллын компаниудтай хамтран мэдээлэл өгөх, тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, иргэдийн аяллын боловсролыг дээшлүүлэх зорилгоор Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдийн талбайд 07 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд Гэр мэдээллийн төв, • Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төв ажиллуулах тухай” А/543 дугаар захирамжийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийн “Чингис хаан” Олон улсын нисэх онгоцны буудалд олон улсын стандарт (ISO 14785)-д нийцсэн “Жуулчны мэдээллийн төв”-ийг Аялал жуулчлалын хөгжлийн төв (ТӨҮГ)-тэй хамтран шинээр ажиллуулж, нийт 5100 гаруй иргэнд мэдээлэл, зөвлөмж өгсөн.</p>	<p>100%</p>
2.	<p>3.4.1.2.1. Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлнэ.</p>	<p>ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 15.0 сая.төг</p>	<p>Оролцогч сонирхогчдын тоо</p>	<p>5000</p>	<p>5000-6000</p>	<p>-Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийслэлийн мотоцикл, мото спорт сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, түүгээр дамжуулан түүх соёл, ёс заншил, өв уламжлалаа олон нийтэд сурталчлах, залуусын эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хөрш зэргэлдээ болон гуравдагч орнуудад эх орноо сурталчлах, жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагддаг “Талын салхи” Олон улсын мото наадам ковид-19 цар тахлаас шалтгаалан</p>	<p>90%</p>

	Арга хэмжээ-3: 1. “Талын салхи” олон улсын мото наадам арга хэмжээ зохион байгуулах					зохион байгуулагдаагүй бөгөөд “Талын салхи” Олон улсын мото наадмын тухай тухай зурагт хуудас, видео танилцуулга хийж, газрын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 18,490 хүнд сурталчилсан.	
3.	Арга хэмжээ-4: 2. “Дээлтэй Монгол” наадам арга хэмжээ зохион байгуулах	ҮИБНЗБХ 20.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	7000	7000-8000	-Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, дэлхий дахинд Монгол үндэстэн гэдгээ түгээн таниулах, үндэсний хувцсаараа дамжуулан үр хойчдоо түүх, соёл, уламжлалаа өвлүүлэн үлдээх зорилготой “Дээлтэй Монгол наадам”-ыг нийслэлийн Засаг даргын 2021 оны А/541 дүгээр захирамжийн хүрээнд 15 дахь зохион байгууллаа. -“Дээлтэй Монгол” бүжгийн уралдааныг 07 дугаар сарын 09-ний өдрөөс 1 сарын хугацаанд цахимаар зарлаж, уралдаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 20 аймаг, 6 улсаас нийт 5.000 гаруй оролцогч, 200 гаруй бичлэг ирүүлсэн бөгөөд шилдэг 10 оролцогчийг шалгаруулан “Дээлтэй өглөө” шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг Өглөөний гудамжинд зохион байгуулж 1,000 гаруй хүн үзэж сонирхсон. -“Дээлтэй Монгол наадам”-ын хүрээнд “Монгол костюмс” ХХК, Цагдаагийн Ерөнхий газрын “Сүлд” чуулга, “Сэмүүн студи”-тэй хамтран Монголын 9 хаадын тамганы “Тэнгэрийн тамга” бүжгэн контентийг бүтээж, 3,000 гаруй хүн үзэж сонирхсон. -“Дээлтэй Монгол наадам”-ын нийт мэдээллийг телевиз, олон нийтийн сүлжээгээр 1,852,575 хүнд хүргэсэн.	100%
4.	Арга хэмжээ-5: 3. “Уухай” шагайн харвааны наадам арга хэмжээ зохион байгуулах	ҮИБНЗБХ 20.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	-	500-1000	-Үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор “Уухай” шагайн харвааны наадмыг Монголын Шагайн харвааны холбоотой хамтран 10 дугаар сарын 17-ны өдөр Монгол бөхийн өргөөнд цахимаар зохион байгууллаа. -Тус наадамд нийт 63 баг 504 тамирчид оролцон цэц мэргэнээ сорьж тэргүүн, дэд, гутгаар байр, шилдэг 4	100%

						багийг шалгаруулж цом, медаль, өргөмжлөл гардуулсан. -“Уухай” шагайн харвааны наадам удирдамж, зурагт хуудас, сурталчилгааны танилцуулга, контент нэвтрүүлэг бэлтгэн нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Шагайн холбооны цахим хуудсанд байршуулж 34,700 хүн, шигшээ багуудын тоглолтын шууд дамжуулалтыг 76,600, нийт 111,300 хүн үзэж сонирхсон.	
5.	Арга хэмжээ-6: 4. “Солонгосын долоо хоног” арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 20.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	8000	8000-9000	-Бүгд найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран “Солонгосын долоо хоног” арга хэмжээг цахимаар буюу “NTV” телевизийн “Эхнэрийн заавраар” нэвтрүүлгийн тусгай дугаарыг бэлтгэж, нэвтрүүлэгт урлаг, соёл, спортын олны танил хүмүүсийг гэр бүлийн хамт оролцуулан Солонгос үндэсний хоолыг хэрхэн хийх талаар нэвтрүүлэг бэлтгэн хүргэж, олон нийтийн сүлжээгээр 221, 000 хүн үзэж сонирхсон.	100%
6.	Арга хэмжээ-7: 5. “Хийморь” олон улсын морьт харвааны тэмцээн арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 15.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	3000-5000	3000-5000	-Үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан Монгол Улсыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын жуулчдыг татах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хийморь” олон улсын морьт харвааны наадмыг 3 дахь жилдээ нийслэлийн Засаг даргын 2021 оны А/691 дүгээр захирамжийн хүрээнд “Монголын морьт харваачдын холбоо”-той хамтран 09 дүгээр сарын 04,05-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж, тэмцээнд Монгол Улсаас Хан Монгол морьтны холбоо, Дэлт сум клуб, Хаадын хаан клуб, Эвт сум клуб зэрэг 6 клубын шилдэг 24 харваач, Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Швед, Франц, Унгар улсаас 20 гадаадын харваач, нийт 44 харваачид оролцож, цахим наадмыг олон нийтийн сүлжээгээр 32.659 хүнд хүргэсэн.	100%
7.	Арга хэмжээ-8: 6. “Хуралдайн наадам-Шонхорын баяр” арга хэмжээ зохион байгуулах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 5.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	500	1000-2000	-Монгол улсын түүх, соёл, уламжлалыг дэлхий дахинд сурталчлан таниулах, дотоодын болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор “Хуралдайн наадам-Шонхорын баяр” арга	90%

						<p>хэмжээг цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан ажлын хэсгийн уулзалт зохион байгуулсан.</p> <p>-Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 176, 259 дүгээр тогтоолын хүрээнд олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах боломжгүй тул арга хэмжээ цуцлагдсан.</p> <p>-“Хуралдайн наадам-Шонхорын баяр”-ыг 2022 онд зохион байгуулах сурталчилгааны зурагт хуудсыг газрын цахим хуудсанд байршуулж, 2863 хүнд хүргэсэн.</p>	
8.	<p>Арга хэмжээ-9: 7. “Улаанбаатар” Үндэсний хоолны наадам зохион байгуулах</p>	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 25.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	-	1000-1500	<p>-Монгол үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын жуулчдад таниулах, жуулчдад зориулсан арга хэмжээний тоог нэмэгдүүлэх, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын 2021 оны А/691 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг”-ийг “Монголын Зочид буудлуудын холбоо” ТББ, “Монголын Гастроном аялал жуулчлалын холбоо” ТББ-тай хамтран М.Ханддоржийн өргөө цогцолборт 09 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулав.</p> <p>-“Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг”-т оролцсон шилдэг 10 рестораны Монгол үндэсний нэрийн хоол болон Монголын Гастроном аялал жуулчлалын холбооны урласан 5 төрлийн тансаг идээ ундааны дисплей танилцуулгыг гадаад дотоодын жуулчдад зориулсан видео нэвтрүүлэг, контентийг 8 телевиз, “Артгэр”, “Юм олж идий”, “Аяллын тойрог”, “Монголын гастроном аялал жуулчлалын холбоо”, газрын цахим хаягуудаар сурталчлан арга хэмжээний контентийг нийт 169,375 хүн үзэж сонирхсон.</p>	100%
9.	<p>Арга хэмжээ-10: 8. “Улаанбаатар” явган аяллын фестиваль зохион байгуулах</p>	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 10.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	150	150	<p>-Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойг тохиолдуулан “Монголын явган алхалтын холбоо”, “Монгол Оллэ нийгэмлэг”-тэй хамтран “Улаанбаатар явган аяллын фестиваль”-</p>	100%

						ийг 10 дугаар сарын 23-ны өдөр Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах Монгол Оллэ шинэ маршрутаар 3 дахь жилдээ зохион байгуулав. -Налайх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр Өгөөмрийн аманд байрлах "Монгол Оллэ" явган аяллын 3 дугаар зам /17км/-ын нээлтийн арга хэмжээнд газрын дарга А.Ариунгэрэл, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын дарга н.Дуламсүрэн, БНСУ-ын Элчин сайдын зөвлөх Ким Чоль Сан болон бусад албаны хүмүүс оролцлоо. -"Монгол Оллэ" явган аяллын тусгайлан тохижуулсан, тэмдэгжүүлсэн уг замаар нийт 150 гаруй явган алхагчид хамрагдсан бөгөөд "Улаанбаатар явган аяллын фестиваль"-ийн арга хэмжээний 2 контентийг цахимаар нийт 59,342 хүн хүргэсэн.	
10.	Арга хэмжээ-11: 9. "Хаадын чуулбар" Чингис хааны мэндэлсэн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах.	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 30.0 сая.төг	Оролцогч сонирхогчдын тоо	-	1000-2000	-Монгол улсын түүх, соёл, уламжлалыг дэлхий дахинд сурталчлан таниулах, дотоодын болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор анх удаагаа Чингис хааны мэндэлсэн өдрийг тохиолдуулан "Хаадын чуулбар" арга хэмжээг цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан ажлын хэсгийн уулзалт зохион байгуулав. -Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 176, 259 дүгээр тогтоолын хүрээнд олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах боломжгүй тул арга хэмжээ цуцлагдсан. -"Хаадын чуулбар" арга хэмжээг 2022 онд зохион байгуулах сурталчилгааны зурагт хуудсыг газрын цахим хуудсанд байршуулж, 2863 хүнд хүргэсэн	90%
11.	Арга хэмжээ-12: 10. "PLAY TIME" амьд хөгжмийн наадам зохион байгуулах	-	Оролцогч сонирхогчдын тоо	30000	30000-35000	-Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг дэлхийд сурталчлах зорилгоор зохион байгуулагддаг "Playtime" наадмыг Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор	90%

						батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 176, 259 дүгээр тогтоолын хүрээнд арга хэмжээ цуцлагдсан. Наадмын зурагт танилцуулга, мэдээллийг газрын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд сурталчлан 5267 хүн үзэж сонирхсон.	
12.	Арга хэмжээ-13: 11. “Ногоон наадам” ОУ-ын залуучуудын бэсрэг наадам зохион байгуулах	-	Оролцогч сонирхогчдын тоо	150	150	-Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, НҮБ-ын "Тогтвортой хөгжлийн зорилго 2030"-ын хүрээнд “Олон улсын залуучуудын ногоон наадам”-ыг 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулах байсан ч дэлхий нийгмийг хамарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 147 дугаар тогтоолоор "Олон улсын залуучуудын спортын ногоон наадам"-ыг 2025 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.	/-/
13.	Арга хэмжээ-14: 3.4.1.2.2. Улаанбаатар брэнд төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 15.0 сая.төг	Бүтээгдэхүүн, тоо	3 бүтээгдэхүүн, 3500 бараа худалдаанд гаргасан	3	-Улаанбаатар брэнд төслийн хүрээнд Ulaanbaatar бичиглэлийг брэнд болгон гадаад дотоодод сурталчилж ажиллах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: • “Апарт рөүд транс” ХХК-тэй хамтран “Есөн-Эрдэнэ” “Ulaanbaatar” брэндийн бичиглэл бүхий эрүүл мэндийн цайг 200 ширхгийг үйлдвэрлэн зах зээлд худалдаанд гарган үргэлжлүүлэн түгээж ажилласан. • “Адъяа-Учрал” ХХК-тай хамтран “Ulaanbaatar” брэндийн бичиглэл бүхий арьс ширэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг зэх зээлд гаргаж гадаад, дотоод 20 ширхийг танилцуулж сурталчилсан. • “Ulaanbaatar your gateway to Mongolia” буюу Улаанбаатар сэтгүүл, “Ulaanbaatar Official Visitor’s Guidebook” буюу хөтөч ном, “Ulaanbaatar official tourist map” буюу хотын газрын зураг /эвхмэл/ тус бүр 2000 ширхэг нийт 6000 ширхэг сурталчилгааны материалд “Ulaanbaatar” брэнд бичиглэлийг хэвлүүлэн тарааж, нийт 6220 ширхэг бүтээгдэхүүн гаргаж сурталчлан ажиллав.	100%

14.	<p>3.4.1.2.3. Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.</p> <p>Арга хэмжээ-15:</p> <p>1. Их тэнгэрийн амны хадны зураг дурсгалын орчныг тохижуулах, аялал жуулчлалын эргэлтэд оруулах.</p>	-	Хувиар	-	100%	<p>-Улаанбаатар хотод ирж буй гадаад, дотоодын жуулчдыг татах, хотын аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгож зорин очих газрыг нэмэгдүүлэх, түүх, соёлын дурсгалыг олон нийтэд сурталчлан таниулах, аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилгоор Баянзүрх дүүргийн 11-р хороо, Их тэнгэрийн амны хадны зураг орчны тохижилтын ажлын хүрээнд МЗХ2021/13-022 архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, тохижилтын ажлын зураг төсөл, төсвийг “Хязгааргүй шулуун” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэн ажлын зургийг нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргаар батлуулсан.</p> <p>-Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах тухай” А/676 дугаар захирамжийн хүрээнд “Их тэнгэрийн амны хадны зураг”-ийн батлагдсан тохижилтын ажлын зураг, төсөв, архитектур төлөвлөлтийн даалгаврын материал холбогдох материалыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн тендерийн ажлыг зохион байгуулж байна.</p>	90%
15.	<p>Арга хэмжээ-16:</p> <p>2. Дөрвөн хайрханы явган аяллын маршрутыг засварлаж, тохижуулан, аялал жуулчлалын эргэлтэд оруулах.</p>	-	Хувиар	-	100%	<p>Дөрвөн хайрханы явган аяллын маршрутыг засварлан, тохижуулах ажлын хүрээнд “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай нийслэлийн нутаг дэвсгэрт явган аяллын маршрутыг тогтоож, тохижилтын ажилд хамтран ажиллахаар санамж бичгийг байгууллаа.</p> <p>• Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тохижуулах тухай” А/397 дугаар захирамжийн дагуу ажлын зураг, төсөв, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын НХААГ-21/074 дугаартай Сонгинохайрхан уулын явган аяллын чиглэлийг тэмдэгжүүлэх, амрах цэгүүдийн тохижуулах ажлыг гүйцэтгэхээр “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн “Люксландшафт” гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн тохижилтын ажлыг 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээж авсан.</p>	100%

						<ul style="list-style-type: none"> • Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран Чингэлтэй хайрханы явган аяллын замын тохижилтын ажлыг сэргээн засварлах ажлын хүрээнд мэдээллийн самбаруудад байршуулах мэдээллийг шинэчилсэн. • Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/370 дугаар захирамжаар Богдхан уулын Зайсан-Дугуй цагаан чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан, тус газраас Богдхан уулын “Авто зогсоол - Дугуй цагаан” чиглэлийн явган аяллын замын тохижилтын ажлын саналыг танилцуулж, Ажлын хэсгийн хурлын шийдвэрээр архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт хийгдэж байна. 	
16.	<p>Арга хэмжээ-17: 3. Бэлхийн аман дахь Хүннүгийн язгууртны булш дурсгалын орчныг тохижуулах, аялал жуулчлалын эргэлтэд оруулах.</p>	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 70.0 сая.төг	Хувиар	-	100%	<p>-Улаанбаатар хотод ирж буй гадаад, дотоодын жуулчдыг татах, түүх, соёлын дурсгалыг олон нийтэд сурталчлан таниулах, аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилгоор “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр хийхээр төлөвлөсөн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын зураг төсөл гүйцэтгүүлэх тухай” А/631 дүгээр захирамжийн хүрээнд 12.7 га талбай бүхий газрын кадастрын зураг, тохижилтын дэвсгэр зургийг “Шинэ кадастр” ХХК-ээр гүйцэтгүүлж, “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлын МЗХ2021/13-021 дугаар архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, “Батдах” ХХК-тай гэрээ байгуулан тохижилтын ажлын зураг төсөл, төсвийн ажлыг гүйцэтгүүлж байна.</p> <p>-Тохижилтын ажлын хүрээнд Монгол, Унгар улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, Монгол-Унгарын археологийн экспедицийн 60 жилийн ойд зориулан түүхэн дурсгалын багана /2x0.5/ босгохоор ажиллаж байна.</p>	70%

3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.							
1.	3.4.2.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Арга хэмжээ-18: 1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад дотоодод түгээн цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 60.0 сая.төг	Контент үзэгч, тандалтын тоо	2 контент 20.000 хүн үзсэн	1 контент 20.000 хүн үзсэн байна	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны танилцуулга, цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай” А/624 дүгээр захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны танилцуулга видео хийх ажлыг “Херо интертайминт групп” ХХК, www.visitulaanbaatar.mn цахим хуудсыг гадаадын жуулчдад зориулсан Улаанбаатар хотын түүх, соёл, нүүдэлчин ахуйгаа авч үлдсэн орчин үеийн хот дүр төрхийг харуулсан дизайнтай, нүүр, хотын түүх, мэдээ, үйлчилгээний байгууллага, эвент арга хэмжээ, вертаул гэсэн 6 үндсэн цэстэй www.visitulaanbaatar.net /англи хэл/ дээрх цахим хуудас шинэчлэх ажлыг “Art agency” ХХК, Улаанбаатар хотын өнгө төрхийг харуулсан 360 градус эргэдэг 4 багц бүхий 25 зурагтай вертаул сан үүсгэх ажлыг “Эй Эл Жи Эс” ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн, хүлээн авч хөгжүүлэлтийг хийж ажиллаж байна.	100%
2.	Арга хэмжээ-19: 2. “Ulaanbaatar your gateway” сэтгүүл, хөтөч ном, газрын зураг зэргийг шинэчлэн хэвлүүлэх.	-	Тоо	-	-	“Ulaanbaatar your gateway to Mongolia” буюу Улаанбаатар сэтгүүл 2000 ширхэг, “Ulaanbaatar Official Visitor’s Guidebook” буюу Хөтөч ном 2000 ширхэг, “Ulaanbaatar official tourist map” буюу Хотын газрын зураг /эвхмэл/ 2000 ширхэг нийт 6000 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлсэн.	100%
3.	Арга хэмжээ-20: 3.4.2.2. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцож Улаанбаатар хотыг сурталчлан таниулна. “Франкфурт”, “Котфа”, “ФАТА”, “ITM” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНХАУ-ын аялал жуулчлалын өдөрлөгт	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 245.0 сая.төг	Тоо	4	6	-Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо 6 дугаар сард зохион байгуулагдсан 36 дахь удаагийн “КОТФА” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин Сайдын яам, МИАТ ХХК, “Mongolia 7 Days” зэрэг аялал жуулчлалын байгууллагууд оролцсон. Тус газраас Сөүл дэх Улаанбаатар хотын төлөөлөгчтэй хамтран Улаанбаатар хотын тухай видео танилцуулга, сурталчилгааны материалыг 1000 гаруй жуулчдад өгсөн. Улаанбаатар хотын видео танилцуулга, Монголын үндэсний хувцасны үзүүлбэр, урлагийн тоглолт, уран зураг, бэлэг	90%

	<p>оролцож Улаанбаатар хотыг сурталчлах, Монгол-Орос-Хятад гурван улсын Сайд нарын зөвлөлийн 6-р хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулах.</p>					<p>дурсгалын худалдаа зэргийг зохион байгуулж үзэсгэлэнд дэлхийн 70 улсын ЭСЯ, иргэний нисэхийн компаниуд болон дотоод, гадаадын аялал жуулчлалын 200 гаруй байгууллага оролцож, 13,000 гаруй хүн үзэж сонирхсон.</p> <p>-Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран "ITM 2021" аялал жуулчлалын үзэсгэлэн "Хүртээмжтэй аялал жуулчлал" уриан дор 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 хоног Мишээл экспо төвд зохион байгуулагдлаа. Энэ удаагийн үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь нийслэл хотод аялал жуулчлалын чиглэлээр баримталж байгаа бодлого, шийдвэрийг сурталчлах, -гадаад, дотоодын иргэд жуулчдад үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй чанартай болгохын тулд аялал жуулчлалын байгууллагууд, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, түншлэл тогтоох, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, хотын аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, нийслэлийн иргэд, хүүхэд залууст хотын түүх, соёл, дурсгалт газар, дурсгалт барилга, үзмэрүүд, хотын өнөөгийн хөгжлийг танилцуулж, улмаар бахархах, хайрлах, хамгаалах сэтгэгдлийг төрүүлэх, иргэдийн аяллын боловсролыг дээшлүүлэх, хотын соёлд суралцуулах зорилготойгоор "Сити тур" төслийг танилцуулж нийт 800 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажиллав.</p> <p>- Дэлхийн өвлийн хотуудын дарга нарын 19 дэх удаагийн хурал 2021 оны 11 дүгээр сарын 05-16-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж хуралд Rovaniemi, Norilsk, Novosibirsk, Ulaanbaatar, Changchun, Daqing, Harbin, Jilin, Qiqihar, Shenyang, Sapporo зэрэг нийт 9 улсын 22 хотын дарга, захирагч нар оролцсон бөгөөд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга А.Ариунгэрэл "Улаанбаатар хотын өвлийн аялал жуулчлал" сэдвээр илтгэл тавьж оролцлоо.</p>	
--	---	--	--	--	--	--	--

						<p>- Унгар улсын нийслэл Будапешт хотноо 2021 оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан түүхийн ач холбогдолтой үнэт дурсгалын хадгалалт, хамгаалалт сэдэвт "HUN 2021" олон улсын хуралд газрын дарга А.Ариунгэрэл оролцов.</p> <p>-Монгол-Орос-Хятад гурван улсын Сайд нарын зөвлөлийн 6-р хурлыг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр цахимаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	
3.4.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олог талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.							
1.	<p>3.4.3.1. Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p> <p>Арга хэмжээ-21: 1. Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх контент бэлтгэж үйлчилгээний байгууллагуудад байршуулах</p>	<p>ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 10.0 сая.төг</p>	Тоо	3	1	<p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/752 дугаар захирамжийн хүрээнд Газрын даргын 2021 оны А/60 дугаар тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, батлагдсан төсвийн хүрээнд гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй аялах видео контент, аяллын үед коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 2 төрлийн контент хийх ажлыг гүйцэтгүүлж, урьдчилан сэргийлэх аюулгүйн видео зөвлөмжийг олон нийтийн сүлжээгээр 21,787 хүнд хүргэсэн.</p>	100%
2.	<p>Арга хэмжээ-22: 2. Жуулчдад зориулсан санамж, гарын авлага хэвлүүлж тараах</p>	<p>ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 3.0 сая.төг</p>	Тоо	-	10.000	<p>Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/752 дугаар захирамжийн хүрээнд Монгол улсад аялах хугацаандаа коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэм, зөвлөмжийг дагаж мөрдөх санамж, жуулчны мэдээллийн төвийн мэдээлэл, шаардлагатай утасны жагсаалт болон урьдчилан сэргийлэх санамж бүхий 2 төрлийн 10.000 ширхэг санамж хийж гүйцэтгүүлсэн.</p>	100%

3.	Арга хэмжээ-23: 3. Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж байгаа стандарт, дүрэм, журам, хууль эрх зүйн баримт бичгийн эмхтгэл гарын авлага гаргах	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 3.0 сая.төг	Тоо	-	500	-Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудад салбарын чиглэлээр мөрдөгдөж байгаа хууль эрх зүй, дүрэм журам, стандартыг сурталчлах баримт бичгийн эмхтгэл гарын авлага боловсруулсан. -Ажлын төсөв Ковид цар тахал, гадаад жуулчдын урсгал байхгүй шалтгаанаас нийслэлийн Засаг даргын захирамжийн төслөөр батлагдаагүй хасагдсан болно.	70%
4.	Арга хэмжээ-24: 4. Аялал жуулчлалын дагалдах үйлчилгээний олон улсын ANSI/ACCT 03-2019 Standard-ыг нутагшуулахад орчуулага хийх, хэлэлцүүлэх, санал боловсруулах, хүргүүлэх.	ҮАБСБҮХ, ХСДИТАХЗ 4.0 сая.төг	Тоо	-	1 стандартын төсөл боловсруулж хүргүүлсэн байна	Улаанбаатар хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийслэлийн иргэд, гадаад, дотоодын жуулчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор аялал жуулчлалын дагалдах үйлчилгээний Олон улсын ANSI/ACCT 03-2019 Standard Дүүжин гүүр, Агаарын замын Олон улсын стандартыг нутагшуулах ажлын саналыг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлж, зөвшөөрөл ирсэн. Энэ ажлын төсөв нийслэлийн Засаг даргын захирамжийн төслөөр батлагдаагүй.	70%
5.	Арга хэмжээ-25: 3.4.3.2. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах, ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.	-	Тоо	7.346.3	9.000.0	- Зочид буудлын ерөнхий шаардлага стандарт MNS4588:2008, аялал жуулчлал дэн буудлын ерөнхий шаардлага стандарт MNS5738:2007-г шинэчлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2021 оны А/23 тушаалаар, дэд ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулсан. -Уг ажлын хүрээнд зочид буудал, дэн буудлын стандартыг шинэчлэн боловсруулж, зочин бүртгэлийн цахим програм суурилуулан и-баримтад холбогдох заалтыг тусган холбогдох 11 төрийн байгууллага болон 7 төрийн бус байгууллагаас санал авч төслийг боловсруулан Стандарт, хэмжил зүйн газрын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна	70%
6.	Арга хэмжээ-26: 3.4.3.3. Жуулчдад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага	-	Сургалтад хамрагдагсдын тоо	615	450	-Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран байгаль хамгаалагчид болон тус бүс нутагт аялал	100%

	<p>болон салбарын хүний нөөцийг чадавхжуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.</p>				<p>жуулчлалын дагалдах үйлчилгээ үзүүлдэг /морь, тэмээ унуулах, нохойтой чарга, дүүжин гүүр, гэх мэт/ иргэдийн дунд хууль эрх зүй, эрүүл ахуйн мэдлэг олгох сургалтыг 2021 оны 7 дугаар сард зохион байгуулж, 30 иргэнийг хамруулав.</p> <p>-Байр сууцны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын удирдах болон үйлчилгээний ажилтнуудад зориулсан “Хууль эрх зүй, аюулгүй байдал, эрүүл ахуй, стандартын мэдлэг олгох” сургалтыг 2021 оны 07 дугаар сарын 21, 22-ны өдөр цахимаар зохион байгуулж нийт 160 ажилтан, албан хаагчийг хамруулсан.</p> <p>- Бүгд найрамдах Хятад Ард Улсын Хайнань хотын Худалдааны газар, бизнесийн сургалтын төвөөс “Хөгжиж буй орнуудын аялал жуулчлал ба зочид буудлын менежмент” сэдэвт 2021 оны 07 дугаар сарын 01-14-ний хооронд зохион байгуулагдсан цахим сургалтад зочлох үйлчилгээний салбарын 12 ажилтанг хамруулж, цахимаар гэрчилгээ олгосон.</p> <p>-Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй дэн буудлын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн үйлчилгээний чанар хүртээмж, стандартыг хангаж ажиллах, үйлчилгээний стандартыг сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, хэвшүүлэх хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилготой “Үйлчилгээний чанар-стандарт” сургалтыг Чингэлтэй, Сүхбаатар Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүргийн жишиг дэн буудлуудын байранд Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Өргөө” дэн буудлуудын холбоо ТББ, Айхотел ХХК, Хорека Софт ХХК нартай хамтран зохион байгуулж нийт 35 дэн буудлын удирдах албан тушаалтнууд хамруулав.</p> <p>-Хүннүгийн эзэнт гүрний язгууртны булш, оршуулгын дурсгалт газруудыг ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн жагсаалтад бүртгүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “Хүннүгийн эзэнт гүрний язгууртны булш</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>оршуулгын дурсгалууд: судалгаа, хадгалалт, хамгаалалт, сурталчилгаа” сэдэвт Үндэсний семинарыг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж 30 хөтөч, тайлбарлагчдыг хамруулсан.</p> <p>- Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран хөтөч, тайлбарлагч, дэн буудлын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчдын харилцаа хандлага, жуулчин тээвэр, такси үйлчилгээний ажилчдад зориулсан хууль эрх зүй, аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулахаар Монголын Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо ТББ, Аялал жуулчлалын сургалт, зөвлөгөөний Нона фамили ХХК, Жуулчин тээврийн холбоо ТББ, Аялал жуулчлалын ур чадварын МСҮТ, Ай хотел ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан.</p>		
3.4.4. “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.							
1.	<p>Арга хэмжээ-27: Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	-	Хувиар	-	100%	<p>-“Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулах ажлын хүрээнд суурь судалгааны маягыг боловсруулж, судалгааг Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд болон байгууллагын цахим хуудаст байршуулан цахимаар авсан.</p> <p>-Арга хэмжээний төслийг боловсруулах Ажлын хэсгийг Үндэсний хөгжлийн газар, салбарын төлөөллүүдээс оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2021 оны 07 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд арга хэмжээний төслийн загварыг боловсруулан ажиллаа.</p> <p>-Мөн арга хэмжээний төслийг 7 зорилтын хүрээнд боловсруулж, төсөлд газрын албан хаагчид, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, харьяа агентлагууд, иргэд, олон нийт болон салбарын мэргэжлийн холбоодоос саналыг авч, нэгтгэсэн.</p> <p>-Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөөд төслийг танилцуулан нийслэлийн Иргэдийн</p>	70%

						Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс санал авч ажиллаж байна.	
3.4.5. “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.							
1.	Арга хэмжээ-28: “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.	-	Хувиар	-	100%	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/679 дүгээр тушаалаар байгуулагдсан “Ковидын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээх санал боловсруулах Ажлын хэсэг”-т ажилласан. -“Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтан болон байгууллагуудаас санал авч нэгтгэн, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Аялал жуулчлалын Зөвлөлийн даргад танилцуулж, тус зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг хүргүүлсэн.	70%
2.Төрийн үйлчилгээний чиглэлээр							
1.	Арга хэмжээ-29: “Улаанбаатар травэл экспо-2021” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулах	Байгууллагын урсгал зардал	Хувиар	100%	100%	-Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран 7 дахь жилдээ “Улаанбаатар Травэл Экспо-2021” үзэсгэлэнг цахимаар 05 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулж, аялал жуулчлалын салбарын 107 байгууллага оролцсон. -Монголд үйл ажиллагаа эрхлэгч компаниудын санал болгох шинэ аяллын маршрут, үнэ болон бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга, гадаадад аялуулагч тур оператор компаниудын бүтээгдэхүүн, клубуудын танилцуулга зэргийг www.ubtourism.org цахим хаягаар авах боломжийг бүрдүүлсэн. -Цахим үзэсгэлэнгийн үеэр 21 аймгийн танилцуулга, инфографик, “Мэргэжилтнүүдтэй хамт 3 минут” цуврал 9 төрлийн видео контент, цар тахлын үеийн аялал жуулчлалын тухай видео зэргийг иргэдэд танилцуулан цахимаар зохион байгуулав.	100%
2.	Арга хэмжээ-30:	Байгууллагын	Тоо	2500	2500	-Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Үндэсний их баяр наадмын талаар авах арга хэмжээний тухай”	/-/

	Үндэсний их баяр наадам үзэх жуулчдын билетийг захиалга авах, дүнг нэгтгэх, олгох	урсгал зардал				183 тогтоолоор Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт нэмэгдэж, улсын хэмжээнд халдварын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын Хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд хязгаарласан шийдвэрийн хүрээнд арга хэмжээг хойшлуулж 2022 онд хамтад нь хийхээр шийдвэрлэсэн.	
3.	Арга хэмжээ-31: Стандартын шаардлага хангасан байгууллагуудад зөвшөөрөл олгоно.	Байгууллагын урсгал зардал	Тоо	461	500	- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хүрээнд E-Mongolia нэгдсэн системээр зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлт ирүүлсэн хүсэлтийн дагуу үзлэг шалгалт зохион байгуулж, стандартын шаардлага хангасан 254 зочид буудал, 133 дэн буудал, 76 амралтын газар, 11 жуулчны бааз нийт 474 газарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.	100%
4.	Арга хэмжээ-32: Улаанбаатар хотын аялал жуулчлалын төрөл бүрийн статистик, судалгааны нэгдсэн мэдээллийн сан үүсгэх	Байгууллагын урсгал зардал	Тоо	2	2	-Байгаль орчин, аялал жуулчлалын яам, "Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨҮГ, "Монгол банк", "Үндэсний статистикийн хороо", "Потеншил Рисерч" компанийн төлөөллүүдтэй уулзаж, аялал жуулчлалын салбарын статистик мэдээ, мэдээллийн аргачлал, урсгалыг шинэчлэх ажлын хүрээнд нэгдсэн маягт, аргачлалыг шинэчлэн гаргахад хамтран ажилласан. -Хил хамгаалах ерөнхий газар, БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газраас 01-10 дугаар сар хүртэлх Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэд, жуулчны статистик мэдээг авч мэдээллийн санд нэгтгэж оруулсан.	100%
5.	Арга хэмжээ-33: Жуулчны улирлыг уртасгах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Улаанбаатарын	Байгууллагын урсгал зардал	Тоо	26	30	-“Улаанбаатар өвлийн хөнгөлөлт” аяныг хэрэгжүүлэхээр үйлчилгээний байгууллагуудын төлөөллүүд томоохон аж ахуйн нэгжүүдийг аянд нэгдэж, өвлийн улирлын хөнгөлөлт үзүүлэх зочлох үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгдэхийг уриалж “Улаанбаатар	100%

	хөнгөлөлт” аяныг зохион байгуулах					<p>травел экспо” цахим үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар аялал жуулчлалын холбооны www.ubtourism.l.org цахим хаягт байршуулж нийт 107 аж ахуйн нэгж, тур оператор, гэр бааз, ТББ, аяллын дэлгүүр, аяллын клуб, даатгал болон бусад байгууллагуудын мэдээ мэдээлэл, 10-50%-ийн хямдрал урамшууллыг зарласан.</p> <p>-Зочлох үйлчилгээний салбарын ХОРЕКА сэтгүүлд Улаанбаатар өвлийн хөнгөлөлтийн уриалгыг байршуулсан.</p>	
6.	Арга хэмжээ-34: Сити тур төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Байгуулагын урсгал зардал 50.0 сая.төг	Хамруулсан хүний тоо	2100	2500	<p>-Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт нэмэгдэж, улсын хэмжээнд халдварын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Сити тур төсөл хэрэгжээгүй.</p> <p>Газрын даргын 2021 оны А/59 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Сити тур төсөл”-ийн автобусны ашиглалт, засвар үйлчилгээнд үнэлэлт дүгнэлт хийж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын техникийн хэлтсийн ажилтнуудаар автобуснуудын тос масло, явах эд ангид засвар үйлчилгээ, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>-Тус газар нь Соёлын солилцоо хөгжлийн төв ТББ-тай хамтран Дэлхийн Аялал жуулчлалын өдөрт зориулсан E-bus city tour хотын аяллыг 9 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж хотын аялалд “Агаарын бохирдол ба Миний хот” эсээ бичлэгийн уралдаанд шилдгээр шалгарсан ахлах ангийн 9, 10-р ангийн нийт 40 сурагчдыг хамрууллаа.</p>	70%
7.	Арга хэмжээ-35: Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн хувиар	96%	100%	<p>-Тайлант хугацаанд газарт тус нийт ирсэн 13 өргөдлийг холбогдох чиг үүргийн хүрээнд 5 албан хаагч хугацаанд нь шийдвэрлэсэн.</p> <p>-Энэ хугацаанд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, зөрчилтэй өргөдөл байхгүй болно.</p>	100%
8.	Арга хэмжээ-36: Төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	-	Тоо	20 сая	20 сая	<p>-Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт нэмэгдэж, улсын хэмжээнд халдварын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан тайлант хугацаанд Сити тур төсөл хэрэгжээгүй.</p>	70%

3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр

1.	<p>Арга хэмжээ-37: Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудыг од, цэцгийн зэрэглэлд хамааруулах</p>	-	Тоо	-	Ирүүлсэн хүсэлт	<p>-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/313 дугаар тушаалаар “Дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журам”-ийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. -Ажлын хэсгээс журмын төслийг шинэчлэн боловсруулан гурван удаагийн хэлэлцүүлэгийг зохион байгуулж, санал авах түвшинд ажлын явц хийгдэж байгаа учраас хяналтын ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна.</p>	70%
2.	<p>Арга хэмжээ-38: Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх</p>	-	Хувиар	90%	100%	<p>- Газрын үйл ажиллагааны тайланд 2021 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөг баталж, Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг тухайн бүр гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, зөвлөмж хүргүүлэн ажилласан. -Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3 арга хэмжээний хэрэгжилт 43%, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2021 онд хамтран ажиллах гэрээний 10 арга хэмжээний хэрэгжилт 78%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 3-р улирлын байдлаар 70% үнэлж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох газарт хүргүүлсэн. -“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд 2021 оны байдлаар 4 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 25 зүйл, заалтын хэрэгжилтийг дүгнэхэд, гүйцэтгэл 98.8 хувь буюу “бүрэн хэрэгжсэн” үр дүнтэй хэрэгжсэн. -Байгууллагын хэмжээнд 2021 оны байдлаар 35 захирамжлалын баримт бичгийн нийт 48 заалт үүрэг, даалгавраас бүрэн хэрэгжсэн 46, хэрэгжих</p>	100%

						шатандаа 2 буюу 98.75 хувийн биелэлттэй гарч, тухай бүр www.Monitoriq.ulaanbaatar.mn програмд тайлагнасан.	
3.	Арга хэмжээ-39: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах	-	Хувиар	100%	100%	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/10 дугаар захирамжаар баталсан "2021 оны төсвийн орлогын сарын хуваарь", 2021 оны төсвийн зарлагын санхүүжилтийн хуваарь", "Нийслэлийн 2021 оны төсвийн төсөв хоорондын харилцааны сарын хуваарь"-ийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулан ажиллаж байна.	100%
4.	Арга хэмжээ-40: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсвийн ил тод байдлыг хангах	-	Хувиар	100%	100%	-Шилэн дансны тухай хуулийн дагуу тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт хэтрэлт, аудитын тайлан, дүгнэлт, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд байршуулж, сар бүрийн төсвийн гүйцэтгэл өглөг, авлагын мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж, шилэн дансанд шивж оруулан нийтэд ил тод мэдээлсэн.	100%
Нийт дүн							91.31

ТАНИЛЦСАН:
ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.СОДНОМДЭМБЭРЭЛ